



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дашинчилэн сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/44/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70642580 Цахим хаяг: Ankhubayrd@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	2
1.Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага.....	18
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02 25 № 102
танай _____ ны № _____ т

Г ДАШИНЧИЛЭН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.БОЛОРЦЭЦЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлүүд нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархаагүй байна. Үүнд:

- Харилцагч байгууллагуудаас түүвэрлэн тулгалт хийхэд нийт 175.1 сая төгрөгийн гүйлгээг тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй;
- Нэмэлт санхүүжилтийн орлого, ЗДНХ-өөс нийт 25.9 сая төгрөгийн өвс худалдан авахдаа гэрээ байгуулаагүй, хүлээлцэж авсан акт байхгүй, нярвын тайланд орлого аваагүй бүртгэл тайланд тусгаагүй;
- Бараа материалын үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, тооллогын хөрөнгийн жагсаалтыг нэгтгээгүй;
- Цалингийн зардлаас нийт 41.5 сая төгрөгийн ХХОАТ, НДШ-ийн өглөг дансанд давхар бичилт хийгээгүй шууд зардалд бичсэн зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 5.4.1,

D:/bichighereg/2022A4toot

006020180

14.4.1, 14.4.6, 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчин тухай хуулийн 71, 72 дугаар зүйл, Булган аймгийн Засаг даргын 2020 оны 09 сарын 29-ний өдрийн А/424 дүгээр захирамжаар баталсан НБББББ-ийн 5.10.5 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой, үнэн зөв, ангилал, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>144,737,807.92</u>	<u>140,898,835.00</u>
33	АВЛАГА	-	4,480,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	4,480,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	144,737,807.92	136,418,835.00
351	Түүхий эд материал	18,804,709.00	18,804,709.00
35110	Тусгай зориулалттай материал	18,804,709.00	18,804,709.00
354	Хангамжийн материал	96,858,098.92	87,509,126.00
35410	Бичиг хэргийн материал	43,476,969.00	42,852,775.00
35420	Аж ахуйн материал	50,415,512.92	41,445,918.00
35440	Түлш, шатах тослох материал	2,965,617.00	3,210,433.00
35600	Мал амьтад	29,075,000.00	30,105,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,145,068,866.05</u>	<u>1,079,528,713.98</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,145,068,866.05	1,079,528,713.98
392	Биет хөрөнгө	1,136,174,366.17	1,069,071,713.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	631,114,649.68	631,114,649.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	(301,118,532.45)	(314,845,508.13)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	365,364,800.00	363,364,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(217,183,629.39)	(232,512,762.31)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	106,093,475.15	114,238,542.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(55,303,697.19)	(67,739,241.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,031,111.87	47,689,347.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,143,261.46)	(22,831,702.13)
39209	Зам, гүүрийн байгууламж	335,832,935.00	376,468,603.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(279,001,927.16)	(355,363,456.32)
39214	Бусад үндсэн хөрөнгө	718,105,148.00	718,105,148.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(188,616,705.88)	(188,616,705.88)
393	Биет бус хөрөнгө	8,894,499.88	10,457,000.00
39301	Програм хангамж	4,455,500.00	6,555,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,993,000.12)	(4,530,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,432,000.00	8,432,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,289,806,673.97</u>	<u>1,220,427,548.98</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,289,806,673.97</u>	<u>1,220,427,548.98</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,289,806,673.97	1,220,427,548.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	371,036,961.17	371,036,961.17
51101	Өмч: - төрийн	371,036,961.17	371,036,961.17
512	Хуримтлагдсан үр дүн	605,088,784.56	535,709,659.57
51210	Өмнөх үеийн үр дүн	605,088,784.56	605,088,784.56
51220	Тайлант үеийн үр дүн	-	(69,379,124.99)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	313,680,928.24	313,680,928.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,289,806,673.97</u>	<u>1,220,427,548.98</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	547,850,381.25	603,456,268.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76,670,558.25	89,239,668.00
120	Нийтлэг татварын бус орлого	76,670,558.25	89,239,668.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	76,670,558.25	89,239,668.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,160,850.00	3,587,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	72,509,708.25	85,652,468.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	471,179,823.00	514,216,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	91,072,723.00	116,774,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,000,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,400,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,672,723.00	116,774,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	380,107,100.00	397,442,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	380,107,100.00	397,442,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	634,197,899.22	645,339,304.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	634,197,899.22	645,339,304.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	580,100,585.91	613,394,510.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	241,042,843.00	222,886,534.00
210101	Үндсэн цалин	143,309,944.00	149,712,893.00
210102	Нэмэгдэл	50,529,573.00	44,417,707.00
210105	Гэрээт ажлын хөлс	47,203,326.00	28,755,934.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,461,951.69	29,059,213.66
210201	Тэтгэврийн даатгал	20,789,258.50	20,166,916.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,413,096.74	2,237,398.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,983,225.00	1,779,559.88
210204	Ажилгүйдлийн даатгал	479,888.31	443,467.35
210205	Эрүүл мэндийн даатгал	4,796,483.14	4,431,870.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,290,042.00	49,649,069.00
210301	Гэрэл, цахилгаан	5,426,696.00	5,354,782.00
210302	Түлш, халаалт	12,663,346.00	23,173,800.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	21,120,487.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,508,619.00	28,848,528.00
210401	Бичиг хэрэг	2,358,470.00	2,341,090.00
210402	Тээвэр, шатахуун	11,321,157.00	20,584,134.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,828,992.00	2,745,804.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		999,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		178,000.00
2105	Нормативт зардал	997,600.00	1,679,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	997,600.00	1,679,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,561,300.00	6,065,110.00
210604	Урсгал засвар	5,561,300.00	6,065,110.00
2107	Томилолт, зочны зардал	1,493,000.00	1,498,000.00

Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	1,493,000.00	1,498,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,956,838.00	1,032,453.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,695,741.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	141,570.00	202,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	369,275.00	400,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.00	260,000.00
210807	Газрын төлбөр	314,252.00	170,053.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	259,788,392.22	272,675,803.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,183,223.00	115,226,933.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	206,900.00	1,250,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	160,398,269.22	156,198,870.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,097,313.31	31,944,793.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,905,200.00	30,144,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		10,254,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,575,200.00	16,110,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,330,000.00	3,780,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,192,113.31	1,799,993.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,192,113.31	1,799,993.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(86,347,517.97)	(41,883,036.07)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	18,192,113.31	15,820,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	18,192,113.31	15,820,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	52,494,763.31	43,316,088.92
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	34,302,650.00	43,316,088.92
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	18,192,113.31	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(34,302,650.00)	(27,496,088.92)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(120,650,167.97)	(69,379,124.99)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн / төгрөгөөр /
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	371,036,961.2	313,680,928.2	605,088,784.6		1,289,806,674.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	371,036,961.2	313,680,928.2	605,088,784.6	-	1,289,806,674.0
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	371,036,961.2	313,680,928.2	605,088,784.6	-	1,289,806,674.0
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	371,036,961.2	313,680,928.2	605,088,784.6	-	1,289,806,674.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	371,036,961.2	313,680,928.2	605,088,784.6	-	1,289,806,674.0

БУА-2022/44/НА-СТА-ТШЗ

D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(69,379,125.0)		(69,379,125.0)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	371,036,961.2	313,680,928.2	535,709,659.6	-	1,220,427,549.0

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	475,640,673.00	517,803,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,460,850.00	3,587,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,460,850.00	3,587,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,460,850.00	3,587,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,460,850.00	3,587,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	471,179,823.00	514,216,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	91,072,723.00	116,774,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,000,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,400,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,672,723.00	116,774,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	380,107,100.00	397,442,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	380,107,100.00	397,442,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	473,890,873.00	492,780,750.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	473,890,873.00	492,780,750.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422,973,559.69	459,535,956.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	241,042,843.00	222,886,534.00
210101	Үндсэн цалин	142,609,944.00	151,206,869.00
210102	Нэмэгдэл	50,812,210.00	45,357,246.00
210105	Гэрээт ажлын хөлс	47,620,689.00	26,322,419.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,461,951.69	29,059,213.66
210201	Тэтгэврийн даатгал	20,789,258.50	20,166,916.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,442,534.74	2,237,398.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,953,787.00	1,779,559.88
210204	Ажилгүйдлийн даатгал	479,888.31	443,467.35
210205	Эрүүл мэндийн даатгал	4,796,483.14	4,431,870.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,240,183.00	49,649,069.00
210301	Гэрэл, цахилгаан	5,107,237.00	5,354,782.00
210302	Түлш, халаалт	11,932,946.00	23,173,800.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	21,120,487.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,752,262.00	17,807,194.00
210401	Бичиг хэрэг	2,358,470.00	2,353,590.00
210402	Тээвэр, шатахуун	13,504,800.00	9,707,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,888,992.00	2,745,804.00

Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,000,000.00
2105	Нормативт зардал	997,600.00	3,099,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	997,600.00	3,099,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,604,300.00	6,419,940.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	220,000.00
210604	Урсгал засвар	5,604,300.00	6,199,940.00
2107	Томилолт, зочны зардал	1,493,000.00	1,498,000.00
210702	Дотоод албан томилолт	1,493,000.00	1,498,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,276,297.00	1,032,453.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,015,200.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	141,570.00	202,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	369,275.00	400,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.00	260,000.00
210807	Газрын төлбөр	314,252.00	170,053.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,105,123.00	128,084,253.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,613,223.00	126,934,253.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	491,900.00	1,150,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,917,313.31	33,244,793.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,725,200.00	26,964,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		10,254,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,575,200.00	16,110,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,150,000.00	600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,192,113.31	6,279,993.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,192,113.31	6,279,993.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,749,800.00	25,023,050.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,749,800.00	25,023,050.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,749,800.00	25,023,050.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,749,800.00	25,023,050.00
222001	Тоног төхөөрөмж	1,749,800.00	22,923,050.00
223001	Бусад хөрөнгө		2,100,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,749,800.00)	(25,023,050.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/ төгрөгөөр / Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	419,192,600.00	399,229,806.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	419,192,600.00	377,865,756.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	392,227,800.00	350,900,956.66

Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,093,900.00	222,886,534.00
210101	Үндсэн цалин	163,980,200.00	151,206,869.00
210102	Нэмэгдэл	44,630,800.00	45,357,246.00
210105	Гэрээт ажлын хөлс	26,482,900.00	26,322,419.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,559,500.00	29,059,213.66
210201	Тэтгэврийн даатгал	21,460,300.00	20,166,916.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,524,800.00	2,237,398.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,019,900.00	1,779,559.88
210204	Ажилгүйдлийн даатгал	505,000.00	443,467.35
210205	Эрүүл мэндийн даатгал	5,049,500.00	4,431,870.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,284,700.00	28,089,069.00
210301	Гэрэл, цахилгаан	4,900,000.00	4,897,529.00
210302	Түлш, халаалт	24,234,700.00	23,173,800.00
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	17,740.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,382,800.00	17,807,194.00
210401	Бичиг хэрэг	2,348,600.00	2,353,590.00
210402	Тээвэр, шатахуун	9,707,800.00	9,707,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,326,400.00	2,745,804.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00
2105	Нормативт зардал	3,100,000.00	3,099,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,100,000.00	3,099,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,700,000.00	6,419,940.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,500,000.00	220,000.00
210602	Тавилга	9,000,000.00	-
210604	Урсгал засвар	6,200,000.00	6,199,940.00
2107	Томилолт, зочны зардал	4,736,200.00	1,498,000.00
210702	Дотоод албан томилолт	4,736,200.00	1,498,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,290,700.00	1,032,453.00
210803	Даатгалын үйлчилгээ	326,700.00	202,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	400,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	264,000.00	260,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00	-
210807	Газрын төлбөр	200,000.00	170,053.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,080,000.00	41,009,253.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,930,000.00	39,859,253.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,150,000.00	1,150,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,964,800.00	26,964,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,964,800.00	26,964,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,254,700.00	10,254,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,110,100.00	16,110,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	600,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	21,364,050.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	21,364,050.00

222001	Тоног төхөөрөмж	-	19,264,050.00
223001	Бусад хөрөнгө	-	2,100,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	419,192,600.00	401,029,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	414,192,600.00	397,442,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	414,192,600.00	397,442,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	3,587,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	3,587,200.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	/ төгрөгөөр /
			Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	91,072,723.00	112,294,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	91,072,723.00	112,294,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	87,672,723.00	112,294,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	21,560,000.00
210301	Гэрэл, цахилгаан	-	457,253.00
210303	Цэвэр, бохир ус	-	21,102,747.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,437,500.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,437,500.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,235,223.00	90,734,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,235,223.00	90,734,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,400,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,400,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,400,000.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	91,072,723.00	116,774,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	91,072,723.00	116,774,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,000,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,878,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,194,723.00	116,774,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дашинчилэн сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дашинчилэн сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03/07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дашинчилэн сумын ЗДТГ нь нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн стратеги төлөвлөлтөнд тулгуурлан төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих, үр дүнг тооцох гэж зорилтоо тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.Үүнд:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль -Хүчингүй болж, шинэчлэн найруулагдсан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-ын дагуу байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дашинчилэн сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 697,000.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,455.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 7,841.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газар нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 69,379.1 мянган төгрөгөөр буюу 5.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	4,480.00	4,480.00
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	144,737.80	136,418.80	(8,319.00)
Үндсэн хөрөнгө	1,145,068.80	1,079,528.70	(65,540.10)

Нийт хөрөнгө	1,289,806.60	1,220,427.50	(69,379.10)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,289,806.00	1,220,427.50	(69,378.50)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,289,806.00	1,220,427.50	(69,378.50)

Авлага дансны үлдэгдэл 4,480.0 мянган төгрөг болж мянган 4,480.0 мянган төгрөгөөр өссөн нь төрөөс олгох усны мөнгө 12 дугаар сарын 31-ний өдөр шилжиж ирсэн, сангийн яам гүйлгээгээ хаасан байсан учир зарцуулж чадаагүй авлагаар илэрхийлсэн нь шалтгаалжээ. Авлага дансны өмнөх онуудад үүссэн эрсдэлтэй авлага байхгүй байна.

Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 136,418.8 мянган төгрөг болж 8,319.0 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал акталснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,265,968.6 мянган төгрөг болж 55,539.0 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө худалдан авалт болон үнэ төлбөргүй хандиваар ирсэн хөрөнгөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 25,023.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 65,635.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 35,119.7 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,220.4 мянган төгрөг болж 69,378.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 55,605.9 мянган төгрөгөөр буюу 10.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан Батбродерс ХХК-аас нийгмийн хариуцлагын хүрээнд олгосон орлого, төрөөс хариуцах цэвэр усны орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 11,103.4 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төрөөс хариуцаж буй цэвэр усны зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж шагнал урамшууллын зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 498,823.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хэмнэлтийн горим хэрэгжүүлж 79,630.9 мянган төгрөгөөр бууруулан 419,192.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 419,192.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 414,192.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 5,000.0 төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 397,442.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 3,587.2 мянган төгрөг нийт 401,029.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 399,229.8 мянган төгрөгийг зарцуулж 1,799.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс цар тахлаас урьдчилан сэргийлэх зардал 5000.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас хамтарсан багийн сургалтын зардал 300.0 мянган төгрөг, стастикийн хэлтэсээс 720.0 мянган төгрөг, Хүнс хөдөө аж ахуйн газраас оготно устгалын зардал 22,220.0 мянган төгрөг, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас хүнсний дэмжлэг 500.0 мянган төгрөг, Батбродерс ХХК-аас нийгмийн хариуцлага 40,000.0 мянган төгрөг, Өвөрхангай аймгаас бэлчээр хамгаалах газрын төлбөр 20,000.0 мянган төгрөг, Булган мээж ХХК-аас төрөөс хариуцах цэвэр усны төлбөр 26,040.0 мянган төгрөг, байгаль хамгаалах сангаас биотехникийн арга хэмжээний зардал 1,994.0 мянган төгрөг нийт 116,774.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс зардалд 112,294.0 мянган төгрөгийг зарцуулж 4,480.0 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлүүд нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархаагүй байна. Үүнд:

- Харилцагч байгууллагуудаас түүвэрлэн тулгалт хийхэд нийт 175.1 сая төгрөгийн гүйлгээг тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй;
- Нэмэлт санхүүжилтийн орлого, ЗДНХ-өөс нийт 25.9 сая төгрөгийн өвс худалдан авахдаа гэрээ байгуулаагүй, хүлээлцэж авсан акт байхгүй, няравын тайланд орлого аваагүй бүртгэл тайланд тусгаагүй;
- Бараа материалын үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, тооллогын хөрөнгийн жагсаалтыг нэгтгээгүй;
- Цалингийн зардлаас нийт 41.5 сая төгрөгийн ХХОАТ, НДШ-ийн өглөг дансанд давхар бичилт хийгээгүй шууд зардалд бичсэн зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бодох бүртгэлийн тухай хуулийн

5.1.4, 5.4.1, 14.4.1, 14.4.6, 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчин тухай хуулийн 71, 72 дугаар зүйл, дахь заалт, Булган аймгийн Засаг даргын 2020 оны 09 сарын 29-ний өдрийн А/424 дүгээр захирамжаар баталсан НБББББ-ийн 5.10.5 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой, үнэн зөв, ангилал, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 117 мэдээлэл оруулахаас 115 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 2 мэдээллийг байршуулаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш 2 удаагийн 22,910.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дэх заалттай нийцээгүй;
- Тайлант онд тавилга хэрэгслийн зардалд 8,990.2, урсгал засварын зардалд 6,199.9, тоног төхөөрөмжийн зардалд 10,493.8 нийт 26,236.157.0 мянган

төгрөгийг зарцуулсан, төсвийн хэмнэлт үүсгээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.4, 1.6, 1.7 дэх заалттай нийцээгүй;

- Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам"-тай нийцээгүй байна;

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан бөгөөд акт, албан шаардлага, зөвлөмж хүргэгдээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын өөрийн орлого болон түрээсийн орлогыг нягтлан шалгаж холбогдох шийдвэрийг дээд шатны удирлдагад хүргүүлэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 357,946.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 35,644.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,035.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 319,267.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 0.00 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Биет хөрөнгө худалдан авсан 19,264.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд бие хөрөнгө худалдан авсан зардлаар илэрхийлээгүй, мал амьтадын нас дэвшлийн орлого 15,820.0 мянган төгрөгийг үндсэн хөрөнгө борлуулсны олз дансанд бүртгэсэн, мал амьтадын нас дэвшлийн 560.0 мянган төгрөгийг зарлагаар бүртгэж дасны бичилтийг буруу хийсэн алдааг НББ-ийн тухай хуулийн 15.1 дэх заалтын дагуу залруулсан.

4.2 Төлбөрийн акт

- Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 647.0 мянган төгрөгийг холбогдох журамд нийцэхгүй зардалд зарцуулсан нь Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 1.1 дэх заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна. заалтыг зөрчсөн мөн санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.
- Тус байгууллага нь туслах үйл ажиллагаа эрхэлж малчны цалинд 1,327.7 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т "Туслах үйл ажиллагааны зардалд тухайн үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдсон шууд болон шууд бус бүх төрлийн зардал, өглөг, санхүүгийн үүргийг оруулж тооцно.", 44.3-т "Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.
- Тус байгууллага нь туслах үйл ажиллагаанаас худалдан зарцуулсан тэмээний үнэ 400,000.00 /дөрвөн зуун мянган төгрөг/ төсөвт төвлөрүүлээгүй

БУА-2022/44/НА-СТА-ТШЗ

зарцуулсан зөрчил нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т “ Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

- Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан 425.0 мянган төгрөгийн шагналыг анхан шатны баримтгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6, 13.7 дахь заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.
- Шатахууны картын үлдэгдэл эхний үлдэгдэл тодруулга тайлангийн шатахууны үлдэгдлээс 235.7 мянган төгрөгөөр зөрүүтэй буюу бараа материалын үлдэгдэлд дутуу илэрхийлсэн нь НББ-ийн тухай хуулийн 14.4.1, 14.2.2 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

- Жилийн эцсийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 2 зарлагын 22,910.0 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” , санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Тайлант онд аж ахуйн нэгж байгууллага, хувь хүн, ажиллагсадтай авлага, өглөгийн тооцоо үүсгэх 176,136.7 мянган төгрөгийн ажил гүйлгээг хийснээс тооцоо нийлж тооцооны үлдэгдлийг баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 заалтуудтай бүрэн нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Тайлант онд тавилга хэрэгслийн зардалд 8,990.2, урсгал засварын зардалд 6,199.9, тоног төхөөрөмжийн зардалд 10,493.8 нийт 26,236.157.0 мянган төгрөгийг зарцуулсан, төсвийн хэмнэлт үүсгээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.4, 1.6, 1.7 дэх заалт, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Цалингийн зардлаас цалингийн урьдчилгааг цалингийн өглөг дансанд давхар бичилт хийгээгүй шууд зардалд 41,562.0 мянган төгрөгийг бичсэн дансны бичилтийн алдаа илэрсэн нь санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Нэмэлт санхүүжилтийн орлого, ЗДНХ-өөс нийт 25,930.0 мянган төгрөгөөр өвс худалдан авахдаа гэрээ байгуулаагүй, хүлээлцэж авсан акт байхгүй, няравын тайланд орлого аваагүй бүртгэл тайланд тусгаагүй нь ННБ-ийн тухай хуулийн 5.4.1-д “үнэн зөв байх;”, 14 дүгээр зүйлийн 14.4.1-д “ аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.6-д “ бүх зардал” гэсэн заалттай бүрэн нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

- Нэмэлт санхүүжилт болон ЗДНХ-өөс зарцуулсан нийт 2,348.4 мянган төгрөгийн шатахууны зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичиж зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 14.2-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Бүтэц орон тоонд батлаагүй нийт 4 гэрээт ажилчны цалингийн зардалд 2,623.6 мянган төгрөгийг зарцуулж Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" тухай заалт, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материал, үндсэн хөрөнгө

1.1. Илрүүлэлт:

Бараа материалын үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, тооллогын хөрөнгийн жагсаалтыг нэгтгээгүй зэрэг зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчин тухай хуулийн 71, 72 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчин тухай хуулийн 71, 72 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

2. Дотоод хяналт шалгалт

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-тай нийцээгүй байна;

2.2. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-ыг дагуу байгууллагын онцлогт нийцүүлэн боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дашинчилэн сумын ЗДТГ	17	357,946.8	3	35,644.0	5	3,035.0	7	319,267.3	2	